



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 02 сарын 28 өдөр

Дугаар А/78

Минцалгоовь

Г

Газар эзэмших эрхийг
шилжүүлэх тухай

Г

Монгол улсын Газрын тухай хуулийн 38 дугаар зүйл 38.1, 38.2, 38.4, 38.6 дах заалт, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3 дах заалт, газар эзэмших эрхийг шилжүүлэн авах иргэний хүсэлтийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

Нэг. Сайнцагаан сумын төвийн 7 дугаар багийн нутаг дэвсгэр /Эрчмийн 8-н айлын орон сууцны хойд талд /-т байршилтай иргэн Улцан овогтой Эрдэнэбаатар /ЗЮ:68010816/-ын үйлчилгээний зориулалттай 130м.кв /0,01га/ газрыг Очирсүрэн овогтой Орхонтуул /ЕП:89010203/-д зориулалтаар нь шилжүүлж 28 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

Хоёр. Дээрх иргэнтэй газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгохыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Э.Чагнаадорж/, гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Сайнцагаан сумын Засаг дарга, хотын захирагч /Р.Мөнхтогтох/, аймгийн Мэргэжлийн хяналтын газар /Ш.Төрбат/ нарт тус тус үүрэг болгосугай.

Гурав. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2015 оны 11 дүгээр сарын 24-ны өдрийн А/492 тоот захирамжийн иргэн У.Эрдэнэбаатарт холбогдох хэсэг мөн газар эзэмших 000614609 тоот гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



С.БАТ-ЭРДЭНЭ

0200235